

БАНКНЫ ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМД ОРОХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Банкны тухай хуулийн “Банкны удирдлага, зохион байгуулалт” буюу 4 дүгээр бүлэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А-151 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг хуульд нийцүүлэх шаардлага үүссэн.

ХОЁР. ЖУРАМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2.1. Шинэчлэн боловсруулагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-д дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

Заалт	Одоогийн мөрдөж байгаа журмын заалт	Нэмэлт өөрчлөлт төслөөр	Тайлбар
2.2.3	Банкны хувьцаа эзэмшигч нь (хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол уг хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч) холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг холбогдох баримт материалын хамт банкны ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тухай бүр ирүүлэх бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Монголбанкинд хүргүүлэх.	Банкны <i>эцсийн өмчлөгч, түүний холбогдох, харилцан хамаарал</i> болон нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг холбогдох баримт материалын хамт банкны ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тухай бүр ирүүлэх бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Монголбанкинд хүргүүлэх.	Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17, 3.1.19 заалтад эцсийн өмчлөгч, харилцан хамаарал бүхий этгээдийн хуулийн нэр томъёог тодорхойлсон тул нэмэлт тайлбар шаардлагагүй,
3.5.1	ТУЗ-ийн гишүүн болон түүний төлөөлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн банкинд зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, төлбөр нь чанаргүйд ангилагдсан тохиолдолд тус гишүүнийг ТУЗ-ийн хуралд саналын эрхтэй оролцуулахыг хориглоно	ТУЗ-ийн гишүүн болон түүний төлөөлж буй аж ахуйн нэгж, байгууллагын тухайн банкинд дахь зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, төлбөр нь <i>анхаарал хандуулах болон чанаргүй ангилалд</i> ангилагдсан тохиолдолд	Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дүгээр заалтаар ТУЗ-ийн гишүүд зээл, батлан даалт баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн аливаа өргүй байхыг шаардсан байна.

		тус гишүүнийг ТУЗ-ийн хуралд саналын эрхтэй оролцуулахыг хориглоно	
3.5.2.1	Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд аудит болон эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнд саналын эрхтэйгээр орж ажиллахыг хориглоно	Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд аудит, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх болон эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнд саналын эрхтэйгээр орж ажиллахыг хориглоно (+) цалин урамшууллын, нэр дэвшүүлэх	Банкны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь заалт буюу “Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хорооны гишүүн байхыг хориглоно...”.
6.6	Эрсдэлийн удирдлагын нэгж нь учирч болох эрсдэлийг нэгдэл, охин, хараат компаниуд, салбар нэгж, банкны бизнесийн чиглэл, бүтээгдэхүүн тус бүрээр болон нэгдсэн байдлаар тогтоож, дүн шинжилгээ хийнэ.	Эрсдэлийн удирдлагын нэгж нь учирч болох эрсдэлийг салбар нэгж, банкны бизнесийн чиглэл, бүтээгдэхүүн тус бүрээр болон нэгдсэн байдлаар тогтоож, дүн шинжилгээ хийнэ. (-) нэгдэл, охин, хараат компаниуд	Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтаар банк хараат, охин компанитай байхыг хориглосон.
8.1.3	Банкны толгой болон салбар компаниуд, түүний үйл ажиллагааны талаар;	Банкны толгой болон зэргэлдээ компаний үйл ажиллагааны талаар	Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтаар банк хараат, охин компанитай байхыг хориглосон.